

ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ  
**3.6 ТЭРБУМ ДОЛЛАР**



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ  
**10.7%**



НИЙТ ХАДГАЛАМЖ  
**13.2 ИХ НАЯД ТӨГ**



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР  
**28.7 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР**



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ  
**854 ТЭРБУМ ТӨГ**



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ  
**11%**

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2019 онд: **+6.1%**  
Инфляци: 2019 онд: **+7%**

Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий **-7%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2018 оны тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2HJFlip>

ДНБ-ий өсөлт: 2019 онд: **+6.3%**  
Инфляци: 2019 онд: **+6.8%**


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: **-8.3%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2018 он 4-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 2-р сарын байдлаар 169 тэрбум төгрөгийн ашигтай гарав.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 35.2 хувиар, зарлага 46.8 хувиар тус тус буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 169 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 96.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.



**Ам.долларын ханш өмнөх сараас 16.31 төгрөгөөр буурав.**

Хоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 230 төгрөг буюу 9.6 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 16.31 төгрөг буюу 0.6 хувиар буурч 2633.37 төгрөг болов. 1-р сард гадаад валютын нөөц 3.6 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 2 хувиар, өмнөх оны мөн үеэс 29 хувь нэмэгдсэн байна.




**Инфляцийн түвшин 6.9%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 2-р сарын байдлаар өмнөх сараас 0.5 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар, оны эхнээс 0.5 хувь өсөв. Хүнсний бараа, орон сууц, ус, цахилгаан, хувцас, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ өссөн нь голлон нөлөөлжээ.




**Гадаад худалдааны тэнцэл 256 сая.ам доллар болов.**

2019 оны хоёрдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 1931.1 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 23.4 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 30.4% импорт өмнөх оны мөн үеэс 15.3%-иар өсч гадаад худалдааны тэнцэл 256 сая ам.долларын ашигтай гарлаа.



## 2-Р САРЫН ОНЦЛОХ: ДНБ



Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)

ДНБ 2018 оны 4-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 5.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 18,058 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засаг 6.9 хувиар өсөв. ДНБ-ий 6.9 хувиар өсөхөд үйлчилгээний салбар 5.3%, санхүү, даатгалын үйл ажиллагааны салбар 12.3% аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 6.2% өссөн нь нөлөөлөв.

Үндэсний Статистикийн хорооны тооцооноос харахад өнгөрсөн оны мөн үед эдийн засгийн өсөлт (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 4.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 396.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 5.1% болсон. Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 4%-иар буурсан бол, үйлчилгээний салбар 12%, бүтээгдэхүүний цэвэр татвар 18%-иар тус тус өсчээ.

Улирлын нөлөөллийг арилган тооцооноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 2.5 хувиар өслөө. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 3.8 (13.5%) их наяд төгрөгөөр өслөө. Харин эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 18.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.1 (6.7%) их наяд төгрөгөөр өссөн байна. Уг өсөлтөд бараа, үйлчилгээний экспорт 2 (15.3%) их наяд төгрөг, хөрөнгийн нийт хуримтлал 1.7 (27.2%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

## САРЫН ОНЦЛОХ

**ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ ЭРГЭЛТ 2-Р САРД**

- Манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт энэ оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 1931.1 сая ам.долларт хүрэв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 23.4 хувиар буюу 366.7 сая ам.доллараар өсчээ. Экспорт импортоос давамгайлж, зөрүү нь 256.1 сая ам.доллараар эерэг гарсан байна. Манай улс он гарсаар дэлхийн 111 улстай худалдаа хийснээс 47 улсад бараагаа экспортлож, 109 улсаас гарал үүсэлтэй барааг импортлосон байна. Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын 98.4 хувь буюу нийт экспортын 74.3 хувийг эзлэж байна.

**ХУГАЦАА ХЭТЭРСЭН БОЛОН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ БУУРАВ**

- Банк, санхүүгийн байгууллагуудаас олгосон нийт зээлийн хэмжээ 17.1 их наяд төгрөг болж төгрөгийн зээл 14.4 их наяд, ам.долларын зээл 2.7 их наяд төгрөгийг эзэлж байна. Сүүлийн жилд хэрэглээний зээл өссөөр байгаа нь манай улсын импортын 20 гаруй хувийг хэрэглээний бүтээгдэхүүний зээл эзэлж байна. Импортын зээл өмнө нь хоёр тэрбум ам.доллараас хэтэрдэггүй байсан бол одоо дөрвөн тэрбум ам.долларт хүрч өсчээ. Тиймээс замбараагүй хэрэглээг хумих шаардлага гарч, хэрэглээний зээлийг хумих бодлогыг Монголбанкнаас барьж буй. Зээлийн үлдэгдлийг бүтцээр авч үзвэл: цалин тэтгэвэр 26 хувь, худалдаа 14 хувь, үл хөдлөх 11 хувь, барилга 9 хувь, уул уурхай 7 хувь, автомашин 3 хувийг тус тус эзэлж байна.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 2-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 2-р сар 2019 он, Монголбанк
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)